



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар В/11

Хэрлэн сум

Д.Ганбаатарыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 56 дугаар зүйлийн 56.6 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын удьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул Данзангийн Ганбаатарыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс Баян-Овоо сумын Засаг даргаар томилсугай.

2.Д.Ганбаатарын үндсэн цалинг 2,145,000 (хоёр сая нэг зуун дөчин таван мянга) төгрөг, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3.Д.Ганбаатарт томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ